

2026 ОНЫ 03 ДУГААР САРЫН 04-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2026-03-04

Өндөртолгой

Нийслэл, дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2026 оны 03 дугаар сарын 10-ны “Мягмар” гарагт 12.00 цагт Засаг даргын Тамгын газрын холбогдох бодлогын хэлтэст албан бичгээр, Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд 16.00 цагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг ирүүлэхдээ Нийслэлийн Хяналт-шинжилгээ үнэлгээний газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 2025 оны 44 дүгээр зөвлөмжийн дагуу дараах шаардлагыг ханган тайлагнаж ажиллана уу.

1. Хэрэгжилтийг 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах, үйл ажиллагааны явц бус гарц, үр дүнг тайлагнах.

2. Үүргийн биелэлтийг тогтоосон хугацаанд, нотлох баримтын хамт, бүрэн гүйцэд тайлагнах.

3. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага бус үндсэн буюу бодлого хэрэгжүүлэгч байгууллага нэгтгэн тайлагнах гэсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Хаврын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд эрх шилжүүлсэн байгууллагууд худалдан авах ажиллагааг эрчимжүүлж, 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дуусгах.	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны алба
2.	Төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх.	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс
3.	Камерын хяналтын дэд төвүүдийн ажлыг эрчимжүүлж, нийтийн эзэмшлийн зам талбайг эвдэж, гэмтээсэн тээврийн хэрэгслийг бүртгэх ажлыг зохион байгуулж, мэдээллийг тогтмол танилцуулах.	“Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ, Цагдаагийн хэлтэс
4.	Нийслэлийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төлөвлөх.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Гэрэлтүүлэг Ногоон байгууламж ОНӨААТҮГ
5.	Дүүргийн нутаг дэвсгэр дэх байгууллагуудын гаднах өнгө үзэмжгүй хаяг, реклам болон хашаа, хайс, эвдэрч гэмтсэн шон, самбаруудыг буулгаж цэгцлэх, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэх ажлуудад газар дээр нь хяналт тавьж, зөрчлийг арилгуулах ажлаа эхлүүлэх.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ
6.	Шар усны үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үерийн далан сувгийн лаг, хог хаягдлыг цэвэрлэх бэлтгэл ажлыг сайтар хангаж, зохион байгуулах.	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ
7.	UB-Engineering-ийн ажлыг эрчимжүүлэх.	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс,
8.	Морин уралдаантай холбоотой саналаа Засгийн газарт хүргүүлэх.	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс

9.	Улсын бүртгэл дэх мэдээлэлтэй тулган 10-аас дээш хүүхэд төрүүлсэн иргэдийн судалгааг гаргаж, танилцуулах.	Улсын бүртгэлийн хэлтэс, Статистик
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10.	Төмөр замын эрчим хүчний асуудлаар албан бичиг төлөвлөн ЭХЯ, ЭХЗХ-д хүргэх	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
11.	Уурын зуухны яндангийн утаа шүүгчийг суурилуулах ашиглалтад оруулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Илч-Орд ОНӨААТҮГ
12.	Дээврийн засварын нэгдсэн нэг загварын зурагтай болох	Дүүргийн менежер, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
13.	Мал хориглох бүс, Газрын зөрчил арилгах ажлын хэсгүүдийг хуралдуулах, тус ажлуудыг эрчимжүүлэх	Тамгын газрын дарга, Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Газар зохион байгуулалтын алба
14.	Нийслэлийн Үйлдвэр технологийн паркуудын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулах, бэлтгэл ажлыг сайтар хангах	Багахангайн Үйлдвэр технологийн парк ХК
15.	Нийслэлийн Засаг дарга ирэх 7 хоногт Багахангайн Үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагаатай танилцахтай холбогдуулан дэд станцын барилгын талаарх мэдээллийг тодорхой танилцуулах	Багахангайн Үйлдвэр технологийн парк ХК
16.	Фокус бүлгийн уулзалтыг зохион байгуулах, төлөвлөгөө, хуваарь гаргах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
17.	Зорилтот жилийн хүрээнд зохион байгуулах иргэн, өрх, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөгдсөн ажлуудыг эхлүүлэх	Засаг даргын орлогч, Нийгмийн хөгжлийн хэлтэс
18.	Шар усны үерээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах - Сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд хүргэх - Хуримтлагдсан цасыг тэгшлэх зөөвөрлөх	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Багахангай Тохижилт ОНӨААТҮГ, Онцгой байдлын хэлтэс
19.	Санамж бичгүүдийн биелэлт гарган танилцуулах	Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
20.	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих	Мал эмнэлгийн тасаг, Онцгой байдлын хэлтэс, Цаглаагийн хэлтэс, Хороод
21.	20 машины гражтай холбоотой түрээсийн журмыг эргэн судлан танилцуулах	Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Илч-Орд ОНӨААТҮГ

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТЦЭНГЭЛ